



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2013 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Бүтээгдэхүүнээс дээж авах, түүнийг хадгалах, тээвэрлэх журам”-ыг нэгдүгээр, “Бүтээгдэхүүнээс дээж авах акт”-ын загварыг хоёрдугаар, “Лабораторид дээж өгсөн тэмдэглэл”-ийн маягтыг гуравдугаар, “Бүтээгдэхүүнээс түүвэр дээж авсан тухай тэмдэглэл”-ийн маягтыг дөрөвдүгээр, “Лабораторийн шинжилгээнд хүлээн авах дээжийн тоо хэмжээ”-г тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газар (Б.Ууганбаяр)-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын 2011 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 19, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 04 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД



С.АМАРСАЙХАН

0023100374

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны
10 дугаар сарын 13-ны өдрийн 68 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

БҮТЭЭГДЭХҮҮНЭЭС ДЭЭЖ АВАХ, ТҮҮНИЙГ ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хяналт шалгалт, тохирлын үнэлгээ хийх явцад бүтээгдэхүүнээс дээж авах, хадгалах, тээвэрлэх, лабораторид дээжийг хүлээн авах, шинжилгээний дүнг олгох, төлбөр төлөх, дээжийн тоо хэмжээтэй холбоотой үйл ажиллагааг хуулиар эрх олгосон, хяналтын чиг үүргийг шилжүүлж авсан орон нутаг болон төрийн захиргааны төв байгууллагын албан тушаалтан, лабораторийн албан хаагч, шалгуулагч этгээдүүдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Бүтээгдэхүүнээс дээж авах

2.1. Төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, тохирлын үнэлгээ хийх явцад болон Иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр дээж авч болно.

2.2. Халдварт өвчин болон хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, хүний амь нас эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл үүссэн зэрэг төлөвлөгөөт бус хяналт шалгалт, түүнчлэн урьдчилан сэргийлэх шалгалт, гүйцэтгэлийн шалгалтаар дээж /сонгомол, давхардсан, урьдчилсан, давтан дээж/ авна. Гомдол, маргаан, судалгаа шинжилгээ, халдварт өвчин болон хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн үед авсан дээжийг сонгомол дээж, бүтээгдэхүүний орц найрлага өөр байх тохиолдолд орц тус бүрээс авах дээжийг давхардсан дээж, бараа, бүтээгдэхүүнийг анх удаа импортлохын өмнө урьдчилсан хяналт шалгалтад хамруулах зорилгоор экспортлогч улсын үйлдвэрлэгчээс ирүүлсэн төлөөлөл дээжийг урьдчилсан дээж, хоёр ба түүнээс дээж авах замаар урьдах шинжилгээний үр дүнг нотлох зорилгоор авсан дээжийг давтан дээж, нийт эх үүсвэрийг төлөөлөх чадвар бүхий сонгон авах бараа, бүтээгдэхүүний дээжийг түүвэр дээж гэж тус тус ойлгоно.

2.3. Үйлдвэр, үйлчилгээ, худалдааны газарт үйлдвэрлэж, хадгалж, тээвэрлэж, борлуулж байгаа бүтээгдэхүүний дээж, эд зүйлс, орчны гадаргуугаас арчдасны дээж, эрүүл мэндийн байгууллагаас шинжилгээний дээж, хүрээлэн буй гадаад орчны шинжилгээний дээж, ажлын байрны дотоод орчны агаар дахь химийн шинжилгээний дээжийг авахдаа холбогдох стандарт, заавар (аргачлал)-ын дагуу авна.

2.4. Хяналт шалгалтын явцад бүтээгдэхүүнээс дээж авахад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын /ахлах/ байцаагч бүтээгдэхүүнээс дээж авах акт, дээж өгсөн тэмдэглэл үйлдэнэ. Бүтээгдэхүүн баталгаажуулалтын эрх бүхий шинжээч лабораторид дээж өгсөн тэмдэглэлийг энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу үйлдэнэ.

2.5. Бүтээгдэхүүнээс дээж авах акт, дээж өгсөн тэмдэглэлийг 3 хувь үйлдэж, шалгуулагч этгээдээр гарын үсэг зуруулан баталгаажуулж, шалгуулагч этгээд болон итгэмжлэгдсэн лабораторид 1 хувийг өгч, үлдэх хувийг шалгалтын материалд хавсаргана. Бүтээгдэхүүнээс дээж авах актад улсын /ахлах/ байцаагч, бүтээгдэхүүн баталгаажуулалтын эрх бүхий шинжээчийн үнэмлэх, тэмдгийн албаны болон хувийн дугаарыг бичнэ.

2.6. Хяналт шалгалтын явцад бүтээгдэхүүнээс дээж авахад тухайн шалгуулагч болон үнэлгээнд хамрагдаж буй этгээд ирээгүй тохиолдолд хөндлөнгийн 2 гэрчийг байлцуулан дээжийг авах актад гарын үсэг зуруулж, баталгаажуулна.

2.7. Шалгуулагч этгээд дээж авах явцтай холбогдуулан хяналт шалгалтын эрх бүхий байгууллага, албан тушаалтанд ажлын 5 өдрийн дотор гомдол гаргах эрхтэй.

2.8. Улсын /ахлах/ байцаагч, бүтээгдэхүүн баталгаажуулалтын эрх бүхий шинжээч шинжилгээнд авсан дээжийн ариун чанар, бүрэн бүтэн байдлыг хариуцах бөгөөд, хадгалалт болон тээвэрлэлт, дээжийн хэмжээ, хэмийн /температур/ горимыг баримталж, дээж өгсөн тэмдэглэлийг энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу үйлдэнэ.

2.9. Улсын /ахлах/ байцаагч, бүтээгдэхүүн баталгаажуулалтын эрх бүхий шинжээч дээжийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр лабораторид хүргэхдээ дээж өгсөн тэмдэглэлийг 2 хувь үйлдэн, лаборатори тус бүрд 1 хувийг дээжийн хамт хүлээлгэж өгнө. Бүтээгдэхүүний эрсдэл, тухайн бүтээгдэхүүний онцлог, шинж чанараас хамаарч дээж өгөх лабораториудыг шинжлэх үзүүлэлтийг улсын /ахлах/ байцаагч сонгоно. Шалгуулагч этгээд хүсвэл дээжийг лабораторид хүргэхэд байлцаж болно. Тухайн лаборатори дээжийг шаардлага хангасан нөхцөлд хадгална.

2.10. Бүтээгдэхүүнээс дээж авснаар шалгуулагч этгээдийн үйлдвэрлэлийн горимын хэвийн үйл ажиллагаа алдагдах тохиолдолд түүнийг шинжилсний дараа дээжийг буцаан олгоно. Дээжийг буцаан олгохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:

2.10.1. шалгуулагч этгээд үйлдвэрлэлийн горимын хэвийн үйл ажиллагаа алдагдах талаар үндэслэл бүхий баримт, дээжийг буцаан авах тухай хүсэлтийг лабораторид гаргана.

2.10.2. улсын /ахлах/ байцаагч, бүтээгдэхүүн баталгаажуулалтын эрх бүхий шинжээч шалгуулагч этгээдийн хүсэлтийг үндэслэн дээж буцаан олгох тухай тэмдэглэл үйлдэнэ.

2.10.3. лаборатори тэмдэглэлийг үндэслэн бүтээгдэхүүний дээжийг шалгуулагч этгээдэд буцаан олгоно. Дээжийг буцаан олгоогүй тохиолдолд шинжилгээний дүнг тайлбарын хамт улсын /ахлах/ байцаагчид өгнө.

2.11. Их хэмжээгээр савлагдсан бүтээгдэхүүнээс дээжийг таслан авахад ариун чанар болон шинж чанар алдагдахаар бол дээжийн үлдэгдлийг шалгуулагч этгээдэд буцаан олгоно. Тэмдэглэлийг үндэслэн дээжийн үлдэгдлийг шалгуулагч этгээдэд лаборатори хүлээлгэн өгнө.

2.12. Лабораторийн дотоод хяналтаар болон улсын /ахлах/ байцаагч, бүтээгдэхүүн баталгаажуулалтын эрх бүхий шинжээчийн шийдвэрээр шинжилгээний

дүнг баталгаажуулах зорилгоор лабораторид загвар дээжийг шинжлүүлж болно. Лабораторийн дотоод хяналт болон шинжилгээний дүнг баталгаажуулах зорилгоор лабораторид давтан шинжилгээнд зориулж хадгалж буй дээжийг загвар дээж гэнэ.

2.13. Энэ журмын 3.12-д заасны дагуу шинжилгээ хийсэн дээж нь стандартад заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд шалгуулагч этгээдэд танилцуулж, улсын байцаагч шийдвэрлэнэ.

2.14. Загвар дээжийн шинжилгээний дүнг шалгуулагч этгээд хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргаж болно.

2.15. Цацрагийн шинжилгээнд гадаад орчны усны дээжийг авахдаа 1-2 л эзлэхүүнтэй савыг дүүргэж битүүмжлэн авна. Дээж авсан он, сар, өдөр, цаг, минутыг улсын байцаагчийн тэмдэглэлд бичиж, дээж авснаас хойш лабораторид 24 цагийн дотор шинжилгээнд хүргүүлсэн байна.

2.16. Цацрагийн шинжилгээнд гадаад орчны усны дээжийг тухайн өдөрт нь багтаан шинжилгээ хийнэ. Цацрагийн шинжилгээнд барилгын материал, үйлдвэр, уул уурхай, геологийн бүтээгдэхүүний дээжийг 5 см-ээс бага буталсан, дээжийн жин 1 кг-3 кг, 600 мл эзлэхүүнтэй савыг дүүргэхээр тооцож авна.

2.17. Дээжийг микробиологийн лабораторид 2-4 цаг өсгөвөрлөж, тарилтыг явуулна. Тухайн өдрийн 15 цагаас хойш дээжийг лабораторид хүлээлгэн өгсөн тохиолдолд дараагийн ажлын өдөрт дээжийг авснаар тооцно.

2.18. Шалгуулагч этгээд шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүн, үйлчилгээнээс дээж авхуулахдаа лабораторийн шинжээч- дээж хүлээн авагчийг оролцуулж болно.

2.19. Эмнэлгээс шалтгаалах халдвар, гадаад орчны ариун материалын дээжийг шинжлүүлэх тохиолдолд лабораторид ажлын 1 өдрийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

Гурав. Бүтээгдэхүүний дээжийг хадгалах, тээвэрлэх

3.1. Шинжилгээнд авсан бүтээгдэхүүний дээжийг хадгалах сав, баглаа боодол нь дээжийн шинж чанарт нөлөөлөл үзүүлэхгүй материалаар хийгдсэн, зориулалтын /тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн заасан нөхцөлд/ болон эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байна.

3.2. Хадгалалтын онцгой нөхцөл шаардах дээжийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь холбогдох стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байна.

3.3. Түргэн гэмтэх, хадгалалтын онцгой нөхцөл шаардагдах бүтээгдэхүүний дээжийг зөөвөрлөх зориулалтын тээврийн хэрэгсэлгүй бол термометр бүхий мөстэй сав, зөөврийн хөргөгчийг ашиглана.

3.4. Дээжийг авснаас хойш 2-6 цагийн дотор, орон нутгаас орон нутагт болон Улаанбаатар хотод дээжийг хүргэхээр тээвэрлэсэн тохиолдолд 12 цагийн дотор лабораторид хүргэнэ. Дээжийг тогтоосон хугацаанд хүргэх боломжгүй тохиолдолд лабораторид урьдчилан мэдэгдэж, түргэн гэмтэж муудахаас бусад дээжийг

хадгалалтын горимыг хугацаа, тохирсон хэмийг баримтлан ажлын 3 өдрөөс хэтрүүлэхгүйгээр хүргэнэ.

3.5. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, халдварт өвчин, төрийн айлчлал, төрийн ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа, гадаад дотоодын зочид төлөөлөгчдийн хүлээн авалтын үед болон гомдолтой холбоотой эрүүл ахуй халдвар судлалын шаардлагаар авсан сонгомол дээжийг нэн даруй лабораторид хүргүүлнэ.

3.6. Хадгалалт, тээвэрлэлтийн горим зөрчсөнөөс дээжийн шинж чанар, савны бүрэн бүтэн байдал алдагдсан болон дээжийн хэмжээ хүрээгүй тохиолдолд лаборатори дээжийг хүлээн авахгүй. Дээж нь тухайн сонгон авсан бүтээгдэхүүнийг бүрэн төлөөлж чадах, шаардлага гарсан тохиолдолд шинжилгээг давтан хийхэд хүрэлцэхүйц хэмжээтэй байна.

3.7. Шинжээч дээж хүлээн авагч улсын байцаагч, иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагаас ирсэн загвар дээжийг батлагдсан тоо хэмжээ, савлагдсан дээжийн ариун байдлыг хангах зорилгоор бүрэн битүүмжлэлтэйгээр хүлээн авах бөгөөд хадгалах дээжийн зохих бүртгэлийг цахим программд хөтөлнө.

Дөрөв. Лабораторид ирсэн дээжийг хүлээн авах, бүрдүүлэх бичиг баримт

4.1. Шинжилгээнд хамруулах дээжийг улсын /ахлах/ байцаагч холбогдох дүрэм, журам, тухайн бүтээгдэхүүний дээж авах стандартын дагуу битүүмжлэн авч, шинжлүүлэхдээ дээжийн хамт дараах баримт бичгийн хамт ирүүлнэ. Үүнд:

4.1.1. Гаалийн хяналтын улсын байцаагч.

- а/ Магадлан шинжилгээ хийлгэх тухай шийдвэр;
- б/ Ургамлын хорио цээрийн болон гарал үүслийн гэрчилгээ;
- в/ Төлбөр төлсөн баримт.

4.1.2. Хяналт шалгалтын төв байгууллага болон орон нутагт хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын улсын /ахлах/ байцаагч.

- а/ Хяналт, шалгалтын удирдамж;
- б/ Бүтээгдэхүүнээс дээж авах акт;
- в/ Лабораторид дээж өгсөн тэмдэглэл;
- г/ Орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх байгууллагын албан бичиг;
- д/ Төлбөр төлсөн баримт.

4.2. Иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага.

Иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь албан хүсэлтээр улирал бүр лабораторид дотоод хяналтын дээж шинжилгээнд өгөхдөө шинжлэх дээжээс хамаарч дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

4.2.1. Дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн бол.

- а/ Албан бичиг;
- б/ Төлбөр төлсөн баримт;
- в/ Лабораторид шинжилгээ хийлгэх маягт;
- г/ Бүтээгдэхүүний анализ сертификат (шаардлагатай тохиолдолд)

4.2.2. Импортын бүтээгдэхүүн бол.

- а/ Албан бичиг;
- б/ Төлбөр төлсөн баримт;
- в/ Амьтан, ургамал, бодис, бараа бүтээгдэхүүнийг импортлох үеийн хяналтын хуудас;
- г/ Бүтээгдэхүүний анализ сертификат (шаардлагатай тохиолдолд)
- д/ Лабораторид шинжилгээ хийлгэх хүсэлтийн маягт.

4.3. Шинжилгээтэй холбоотой маргааныг магадлан шинжлэх зорилгоор зөвхөн төрийн байгууллагын болон орон нутгийн лабораториуд хоорондоо шинжилгээ хийх дээжийг өгөхдөө дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

- а/ Хүсэлт гаргасан байгууллагын албан бичиг;
- б/ Бүтээгдэхүүний анализ сертификат (шаардлагатай тохиолдолд)

4.4. Бүтээгдэхүүн баталгаажуулалтын эрх бүхий шинжээч:

а/ Тохирлын үнэлгээ хийх явцад бүтээгдэхүүн баталгаажуулалтын эрх бүхий шинжээч нь түүвэр дээж авах тэмдэглэл;

б/ Шалгуулагч этгээдийн төлбөр төлсөн баримт;

4.5. Лабораторийн шинжээч дээж хүлээн авагч нь батлагдсан тарифын дагуу шинжилгээний төлбөрийн нэхэмжлэлийн хуудсыг бичиж өгнө.

4.6. Шинжээч дээж хүлээн авагч нь дээж хүлээлгэн өгсөн хугацаа, дээжийн нэр, тун, үйлдвэрлэсэн улс, хүчинтэй хугацаа, дээжийн тоо хэмжээ, төлбөр төлсөн баримт, улсын /ахлах/ байцаагчийн нэр, эрх бүхий шинжээч, тэмдэглэлийн дугаар, загвар дээж өгсөн зэрэг мэдээллийг зохих бүртгэлд хөтлөн, холбогдох баримт бичгийг болон дараах нөхцөл байдлыг нягтлан шалгасны үндсэн дээр дээжийг лабораторид хүлээн авна.

4.6.1. Холбогдох баримт бичгийг бүрэн бөглөсөн, бичсэн мэдээлэл нь дээжтэй тохирч байгаа эсэхийг нягтална.

4.6.2. Дээж нь мэдээллээс зөрүүтэй байвал дээж авсан улсын /ахлах/ байцаагч, эрх бүхий шинжээч, хүсэлт гаргасан Иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад мэдэгдэж, тодруулга иртэл түр зуур хадгалах эсвэл буцаана. Өөрчлөлт орсон талаар бүртгэлийг цахим программын дээж бүртгэлийн тайлбар хэсэгт тэмдэглэгээ хийнэ.

4.7. Лаборатори ажлын цагийн хуваарийн дагуу дээжийг хүлээн авна. Ажлын цагаас бусад үед дээж хүлээлгэн өгөх бол ажлын 1 өдрийн өмнө лабораторид урьдчилан мэдэгдэнэ.

Тав. Төлбөр тооцоо хийх, шинжилгээний дүнг олгох

5.1. Шинжээч дээж хүлээн авагч нь баримт бичгийн асуудал бүрэн шийдвэрлэгдсэн дээжийг Лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцооны /ЛМУТ/ программд кодлох бөгөөд шинжээч дээж хүлээн авагч программд бүртгэн шинжилгээнд оруулна.

5.2. Лаборатори нь шинжилгээний дүнг дээжийг шинжилгээнд оруулснаас хойш ажлын 5-8 өдөрт багтаан гаргаж, төлбөр төлсөн баримтыг үндэслэн шинжилгээний дүнг олгоно.

5.3. Дараах тохиодолд лабораторийн удирдлагын зөвшөөрлөөр шинжилгээ хийх хугацааг сунгаж болно.

5.3.1. яаралтай шинжилгээний дээж (төрийн ёслол хүндэтгэлийн болон гадаадын зочид төлөөлөгчдийн хүлээн авалт, нийтийг орныг хамарсан хордлого, хордлогот халдварын шинжилгээ) давхцсан үед.

5.3.2. лабораторид шаардлага хангаагүй дээжийн давтан шинжилгээ хийх үед.

5.4. Шинжлэгдсэн дээж нь стандартын шаардлага хангаагүй тохиолдолд лабораторийн ажилтан Иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад мэргэжлийн зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллах бөгөөд тухайн дээж нь аюулгүй үзүүлэлтээр шаардлага хангаагүй гарсан тохиолдолд давтан шинжилгээнд хамруулж, давтан шинжилгээгээр дахин шаардлага хангаагүй тохиолдолд салбарын улсын байцаагчид мэдэгдэнэ.

5.5. Шинжилгээний дүнгээр дээж нь стандартад заасан шаардлагыг хангаагүй, тухайн бүтээгдэхүүнд давтан шинжилгээ хийсэн, хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, гомдол гарсан тохиолдолд шинжилгээний төлбөрийг шалгуулагч этгээдээс гаргуулна.

5.6. Улсын /ахлах/ байцаагч болон эрх бүхий шинжээчийн өгсөн дээж нь стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлтийн шаардлага хангаагүй тохиолдолд лабораторийн ажилтан шинжилгээний дүнгийн талаарх мэдээг холбогдох улсын байцаагчид тухай бүр, нэгдсэн байдлаар 7-14 хоног тутам Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид мэдээлнэ.

5.7. Стандартын шаардлага хангаагүй дээжийн шинжилгээний дүнгийн мэдээллийг төрийн, орон нутгийн лабораториуд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид ирүүлэх бөгөөд шинжилгээний дүнгээ мэдээллийн нэгдсэн санд тухай бүр хүргүүлнэ.

Зургаа. Шинжилгээний төлбөр

6.1. Дараах тохиолдолд шинжилгээг төлбөрөөс чөлөөлнө:

6.1.1. Төрийн тусгай хамгаалалтын нэгдүгээр зэргийн хамгаалалтад байх албан тушаалтны айлчлалын үед хоол, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хийх шинжилгээ;

6.1.2. Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, дээд, өндөр хэмжээний зочны хүлээн авалт, айлчлалтай холбоотой хийх шинжилгээ;

6.1.3. Хүнсний бүтээгдэхүүн, ус, хөрс, агаар зэргээр дамжин тархдаг нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлт, гамшгийн /онгоцны осол, үер, газар хөдлөлт, галын аюул гэх мэт/ үед хийх шинжилгээ;

6.1.4. Хүнсээр дамжих болон бусад эх үүсвэрийн гаралтай хоолны хордлого, хордлогот халдвар бүртгэгдсэн тохиолдолд шалтгааныг тогтоохоор хийх шинжилгээ;

6.1.5. УИХ, Засгийн газар, ЗГХЭГ-ын хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэнд болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан удирдамжтай хяналт шалгалтын үеэр хийх шинжилгээ;

6.1.6. Эрүүл мэнд болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан шинжилгээт хяналт шалгалтын ажлаа өмнөх оны 12 сарын 10-ны өдрийн дотор лабораторид урьдчилан мэдэгдэж, лабораторийн төлөвлөгөөнд тусгуулж, бэлтгэл ажлыг хангуулсан байна;

6.1.7. Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын чиглэлээр тухайн жилд хийгдэхээр баталсан төлөвлөгөөт хяналт шалгалтын Нийслэлийн төв болон орон нутгийн лабораторийн итгэмжлэлийн хүрээнд ороогүй шинжилгээг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори гүйцэтгэнэ;

6.1.8. Гэмт хэргийн шинжтэй, /цагдаа, тагнуулын байгууллагын албан бичгээр ирүүлсэн дээж/ шинжилгээний төлбөрийг төлөх субъект нь тодорхой бус, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор хийх шинжилгээ;

6.1.9. Лаборатори өөрийн итгэмжлэлийн хүрээнд шинжилгээ гүйцэтгэх чадварыг үнэлэх, үр дүнгийн чанарыг хянах зорилгоор дотоод хяналтын шинжилгээ болон гадаад хяналтын лаборатори хоорондын харьцуулсан шинжилгээ;

6.1.10. Итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн лабораториудын хооронд баталгаажуулах шинжилгээний төлбөрийг тус тус төлбөрөөс чөлөөлж болно.

6.2. Дараах тохиолдолд шалгуулагч этгээд шинжилгээний төлбөр төлнө.

6.2.1. Хяналт шалгалт, тохирлын үнэлгээ хийх явцад шинжилгээний дүнгээр стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангаагүй тохиолдолд тухайн дээжийн төлбөрийг бүтэн төлнө;

6.2.2. Байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн хүсэлтээр лабораторийн маягтын дагуу бөглөж, дээжээ шинжилгээнд хамруулсан;

6.2.3. Шалгуулагч этгээд давтан шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан тохиолдолд;

6.2.4. Халдварт өвчин, хордлого, хоол хүнсний бус /эмийн хордлого гэх мэт/ хордлого гарсан тохиолдолд зөрчил гаргасан шалгуулагч этгээд;

6.2.5. Иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын хүсэлтээр тохирлын үнэлгээ хийсэн болон тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээний дагуу бүтээгдэхүүнээ шинжилгээнд хамруулсан бол төлбөр төлнө;

6.2.6. Хуульд өөрөөр заагаагүй бол бусад тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллага хариуцан төлнө.

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны
10 дугаар сарын 13-ны өдрийн 68 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

БҮТЭЭГДЭХҮҮНЭЭС ДЭЭЖ АВАХ АКТ

2023 оны ...-р сарын ...-ны өдөр

№

Хот, аймаг, сум, дүүрэг

Шалгуулагч этгээдийн нэр, регистрийн дугаар, хаяг, утасны дугаар

Дээж авахад байлцсан шалгуулагч этгээдийн төлөөлөгчийн нэр, албан тушаал, утасны дугаар;

Дээж авсан улсын /ахлах/ байцаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал;

Дээж авах үндэслэл, шаардлага;

Импортолсон улс болон үйлдвэрлэгчийн нэр;

Дээж авсан хугацаа;

Дээж авсан орчны хэм, харьцангуй чийглэг

№	Бүтээгдэхүүний дээжийн нэр, төрөл	Савлалт	Цувралын дугаар	Үйлдвэрлэсэн он сар өдөр, дуусах хугацаа	Импортолсон болон үйлдвэрлэсэн нийт тоо хэмжээ /нэгж/	Дээж авсан тоо хэмжээ /нэгж/	Дээжийн нэгж үнэ /төгрөг/

3 хувь үйлдэв.

АКТ ТОГТООСОН:

(улсын /ахлах/ байцаагчийн албан тушаал үсэг)

(нэр, гарын

/Тэмдэг/

АКТЫГ ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

.....
.....

(шалгуулагч этгээдийн албан тушаал)

(нэр, гарын үсэг)

/Тамга тэмдэг/


Гэрчийн овог нэр, түүний гэрийн хаяг (шалгуулагч этгээд ирээгүй тохиолдолд)

.....
.....

(нэр, гарын үсэг)

.....
.....

(нэр, гарын үсэг)



Монгол Улсын Шадар сайдын 2023 оны
12 дугаар сарын 13-ны өдрийн 48 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

ЛАБОРАТОРИД ДЭЭЖ ӨГСӨН ТЭМДЭГЛЭЛ

Шалгалтын

удирдамжийн

огноо;.....дугаар;.....

Шинжилгээ хийх зорилго;

.....

Дээж авсан үеийн орчны хэм;, харьцангуй чийглэг;

.....

Дээж төлөвлөлт;, хяналтын

түвшин;.....

Дээж өгсөн лаборатори;

.....

№	Бүтээгдэхүүний нэр, төрөл	Үйлдвэрлэсэн улс	Шинжлэх үзүүлэлт

Дээжийг лабораторид өгсөн огноо; 20... оны ... сарын ны өдөр цаг ... минут

Тэмдэглэл;

2 хувь үйлдэв.

Дээж хүлээлгэн өгсөн улсын /ахлах/ байцаагч

.....


/Тэмдэг/

(нэр, гарын үсэг)

Дээж хүлээн авсан албан тушаалтан

.....

(нэр, гарын үсэг)



Монгол Улсын Шадар сайдын 2023 оны
10 дугаар сарын 13-ны өдрийн 68 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

**БҮТЭЭГДЭХҮҮНЭЭС ТҮҮВЭР ДЭЭЖ
АВСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ**

- 1. Тохирлын үнэлгээний удирдамжийн он, сар, өдөр;.....дугаар;.....
- 2. Дээж авсан зорилго:
- 3. Аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, код:
- 4. Дээж нь аль болох: дотоод зах зээлд нийлүүлэх
 экспортод гаргах импортоор нийлүүлэх
- 5. Бүтээгдэхүүний нэр.....-ээс
- 6. Түүвэр дээжийг үйлдвэрлэгч/нийлүүлэгчээс
 гаалийн үзлэгийн явц-д түүвэр дээж авав.

7. Тухайн цуврал бүтээгдэхүүний шинж байдал:

- а/ хэмжээ/биет нэгжээр
- б/ гадаад шинж байдал, савлалт, хадгалалт

.....
..
.....
.....

7. Түүвэр дээжийн хийх сорилт, шинжилгээний үзүүлэлт, холбогдох стандарт техникийн зохицуулалтын нэр, дугаар:

.....
.....
....

8. Шинжилгээ хийх итгэмжлэгдсэн сорилтын лабораторийн нэр:

.....

9. Түүвэр дээж авсан:

- а) Баталгаажуулалтын байгууллагын нэр:
- б) Бүтээгдэхүүн баталгаажуулалтын шинжээч:

..... ()
.....

он, сар, өдөр

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны
10 дугаар сарын 13-ны өдрийн 68 дугаар
тушаалын тавдугаар хавсралт

ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНД ХҮЛЭЭН АВАХ ДЭЭЖИЙН ТОО ХЭМЖЭЭ

№	Бүтээгдэхүүний нэр	Дээжийн хэмжээ /г/
Нэг.Үрийн шинжилгээ		
1.1. Үр тариа		
1	Эрдэнэ шишийн үр	1500
2	Буудай, арвай, хөх тариа, овъёос	1000
3	Бог будаа, чумиза, гурвалжин будаа	500
1.2. Буурцагт ба үет өвслөг ургамлын үр		
4	Морин шош	1000
5	Вандуй, шош, сэрэгзарам, шар буурцаг	1000
6	Гандэгээ, хүнцэнгэ, шошлой, тэжээлийн вандуй	1000
7	Хошоонго, царгас, хошоон, судан өвс	250
8	Согоовор, ойн төмөрдэй	100
9	Ерхөг, ботууль, дурваалинг, үүргэнэ	150
10	Биелэг өвс, улаан толгой	30
1.3. Хүнсний гуатан ба тэжээлийн үндсэн үрт ургамлын үр		
11	Хүрэн манжин, шар манжин, тэжээлийн манжин	800
12	Тарвас, хулуу	500
13	Өргөст хэмх	250
14	Сонгино, бууцай, шанцай	100
15	Төл сонгино	3000
16	Гоньд, лууван, улаан лооль, байцаа	200
1.4. Цэцэгт ургамлын үр		
17	Том урт цэцгүүд /даль, мандирваа/	50
18	Дунд зэргийн үрт цэцгүүд /гол, гэсэр башир/	15
19	Жижиг үрт цэцгүүд /анхилуун, тамхи, хайтан/	10
1.5. Модлог ба бутлаг ургамлын үр		
20	Том үрт ургамал /гүйлс, хуш, царгас, чавга/	1000
21	Дунд зэргийн үрт /алим, тэс, далан хальс/	100
22	Жижиг үрт /улиас, үхрийн нүд/	20
1.6. Тослог ба техникийн ургамлын үр		
23	Газрын самар	100
24	Наранцэцэг, хөвөн, какао, кофе	500
25	Олс, маалинга	500
26	Гич, сархи, өвс	100
27	Зөрөг цэцэг	50
28	Тамхи, хурган засаа	20
Хоёр. Хорио цээрийн шинжилгээ		
2.1. Шинэхэн жимс ба хүнсний ногоо		
29	Хан боргоцой, анар, тарвас, амтат гуа г.м	5500
30	Лийр, нимбэг, бэрсүүт жүрж, алим, тоор	5000
31	Яст жимс- чавга, интоор, мойл, гүйлс, үзэм	3500
32	Төмс, хүнсний ногоо, мөөг	5500

2.2. Бусад		
33	Үр тариа, гурил, элсэн чихэр, бүх төрлийн будаа /шар, цагаан, гурвалжин, хөц/	3500
34	Хөрс	500
35	Шахмал ногоон цай	1500
36	Задгай тамхи	1500
37	Бүр төрлийн самар	1500
38	Бүр төрлийн хатаасан жимс	1500

**ЭМ ШИНЖЛЭХ ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНД ДЭЭЖ
ХҮЛЭЭН АВАХ ТОО, ХЭМЖЭЭ**

№	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний нэр	Дээжийн хэмжээ	Хэмжих нэгж	Дээжийн тоо хэмжээ			Нийт
				Хими	Микробиологи	Загвар дээж	
1	Туншил	≤1 мл	Ампул	30	20	10	60
		≤3 мл		20	15	10	45
		3 мл <		15	15	10	40
		10 мл ≤		10	10	10	30
2	Шахмал, үрэл, капсул хэлбэртэй эм /нийлмэл эмүүд тус бүрд хамаарна./	Дундаж жин ≤300 мг	Ширхэг	60	20	30	110
		Дундаж жин 300 ≤ мг	Ширхэг	50	15	20	85
3	Шахмал, үрэл, капсул, тугнасан нунтаг хэлбэртэй уламжлалт эм		Ширхэг	40	10	20	70
4	Тосон түрхлэг	Дундаж жин ≤5 г	Ширхэг	10	3	5	18
		5 г <	Ширхэг	5	2	5	12
5	Тарилгын шингэн	≤50 мл	Флакон	5	2	5	12
		≤250 мл		3	2	3	8
		500 мл ≤		2	2	2	6
6	Түүхий эд		гр	150	20	0	170
7	Галены бэлдмэл	≤50 мл	Ширхэг	10	2	2	14
		≤100 мл		5	1	2	8
		250 мл ≤		3	1	2	6
8	Эмийн сангийн бэлдмэл	≤50 мл	Ширхэг	10	3	0	13
		≤100 мл		5	2	0	7
		250 мл ≤		3	2	0	5
9	Тарилгын нунтаг	Дундаж жин 1 г ≤	Флакон	10	15	10	35

		Дундаж жин <1 г		30	15	10	55
10	Ургамлын түүхий эд	гр	гр	50	15	0	65
11	Нүд, чих, хамрын дусал, цацлага	≤5-10 мл	Ширхэг	10	3	10	23
		10 мл<		7	2	5	14
12	Сироп, хөвмөл /шингэн, нунтаг/	≤50 мл, г	ширхэг	10	3	10	23
		50 мл, г<		5	2	5	12
13	Тугнасан нунтаг, мөхлөг	<5 г	Ширхэг	30	15	20	65
		<10 г		20	10	10	40
		10 г≤		10	5	10	25
14	Лаа		Ширхэг	40	15	10	65
15	Биобэлдмэл	Тариур ≤3 мл	Ширхэг	20	10	10	40
		Туншил ≤2 мл		20	10	10	40
16	Ариутгалын бодис	≤50 мл	Ширхэг	10	5	5	20
		≤250 мл		5	3	2	10
		250 мл≤		3	2	1	6
		1000 мл≤		0	1	1	2
17	Нэрмэл ус	500 мл≤	Ширхэг	2	1	0	3
18	Диализ ус	250 мл≤	Ширхэг	0	2	0	2
19	Нэг удаагийн тариур	0.5 мл	Ширхэг	30	15	0	45
		1-5 мл		15	15	0	30
		10 мл		15	10	0	25
		20 мл		10	10	0	20
		50 мл		10	5	0	15
20	Мэс заслын утас		Ширхэг	5	6	0	11
21	Мэс заслын бээлий		Ширхэг	10	6	0	16
22	Хөвөн		Ширхэг	5	5	0	10
23	Бинт		Ширхэг	10	5	0	15
24	Нэг удаагийн бээлий		Хайрцаг	0	1	0	1
25	Бэлгэвч		Ширхэг	20	5	0	25
26	Дуслын систем		Ширхэг	3	6	0	9

ХИМИ, ХОР, ХҮНД МЕТАЛЛ, ПАРАЗИТОЛОГИ, МИКРОБИОЛОГИ, ХӨГЦ МӨӨГӨНЦӨР, ЦАЦРАГИЙН
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНД ХҮЛЭЭН АВАХ ДЭЭЖИЙН ТОО ХЭМЖЭЭ

Бүтээгдэхүүний нэр	Микробиологи /г, мл/									Цацраг /мл/	Хүнд металл /г, мл/	Завар дээж /г, мл/	Бүгд /г, мл/
	1	2	3	4	5	6	7	8	9				
0	Нэг. Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээ									7	6	8	9
1	Сүү, сүүн бүтээгдэхүүн /бяслаг, масло г.м/	500	-	150	300	500	300	500	300	500	300	500	2750
2	Мах махан бүтээгдэхүүн	300	300	200	300	300	300	300	300	500	300	500	2700
	Малын Шувууны	300	300	-	-	300	-	300	300	300	300	300	2000
3	Гурил, гурилан бүтээгдэхүүн	300	300	200	300	300	300	300	300	500	300	500	2500
4	Далайн гаралтай бүтээгдэхүүн /загас, хавч, сам хорхой/	300	300	200	300	300	300	300	300	500	300	500	2500
5	Вино	500	-	-	300	1000	300	1000	300	500	300	500	3100
6	Ундаа	500	-	-	300	500	300	500	300	500	300	500	2600
7	Виски, ликер	-	-	-	300	1000	300	1000	300	500	300	500	2600
8	Бэлэн хоол, хагас боловсруулсан бүтээгдэхүүн (пицца, гамбургер)	300	200	200	300	300	300	300	300	500	300	500	2400
9	Чихэр чихэрлэг бүтээгдэхүүн /хатуу, зөөлөн чихэр, зөгийн бал/	300	-	150	250	300	250	300	300	500	300	500	2100
10	Консервло	500	300	200	300	300	300	300	300	500	300	500	2700
	сон	300	300	200	300	300	300	300	300	500	300	500	2500
11	Жимс ногооны	300	-	150	300	300	300	300	300	500	300	500	2150
	Өндөг, өндгөн бүтээгдэхүүн /майонез, хуурай, шингэн, хөлдөөсөн	300	-	200	300	300	300	300	300	500	300	500	2200
12	Шоколад, кремтэй бүтээгдэхүүн	300	-	200	300	300	300	300	300	500	300	500	2200
13	Жимс жимсгэний варень, джем, сироп,	300	200	200	300	300	300	300	300	500	300	500	2400

31	Тамхи	Янжуур	-	-	10 хайр	10 хайрц	10 хайрц	-	10 хайрц	5 хайр	35 хайрцаг
		Дүнс	-	-	300	500	500	-	500	500	1800
Хоёр. Гадаад орчны шинжилгээ											
32	Төвлөрсөн усан хангамж		1000	500	-	-	2000	1000	1000	-	5500
33	Хэсгийн усан хангамж/худаг/		1000	500	-	-	2000	1000	1000	-	5500
34	Гол мөрөн ил задгай ус		1000	500	-	-	1000	1000	1000	-	5500
35	Халуун ус, усан бассейны ус		1000	1000	-	-	2000	1000	1000	-	6000
36	Хөрс, ургамал		500	500	500	-	200	250	1000	-	2950
37	Бохир ус		1000	500	-	-	2000	1000	1000	-	5500
38	Барилгын материал түүний								2000		1000
39	Уул уурхайн ашигт малтмал								2000		1000
Гурав. Гоо сайхан, ахуйн химийн бүтээгдэхүүний шинжилгээ											
40	Саван		100	100	-	-	200	-	500	100	1000
41	Угаалгын нунтаг		100	100	-	-	300	-	500	100	1100
42	Шампунь, шингэн саван, ванны хөөс, ангижруулагч, аяга таваг угаагч шингэн		250	250	-	-	300	~	500	200	1500
43	Шүдний оо		40	40	-	-	120	-	250	50	500
44	Уруулын будаг		10	10	-	-	10	-	-	10	40
45	Энгэсэг, тень, хацар өнгөлөгч		15	15	-	-	20	-	-	15	65
46	Гоо сайхны тос, тосон		50	50	-	-	100	-	250	50	500
47	Гоо сайхны шингэн, тоник, спиртэн бүтээгдэхүүн		50	50	-	-	100	-	-	50	250
48	Үнэртэй ус, дезодорант		30	30	-	-	100	-	-	30	190
49	Сормуусны будаг, контур		10	10	-	-	15	-	-	10	45
50	Хөмсөг, зовхины харандаа, уруул		1ш	2ш	-	-	4ш	-	-	1ш	8ш
51	Үсний будаг, хими		1	1ш/60мл	-	-	1ш/	-	-	1ш/60м	4ш/240мл

52	Хумсны лак, бэхжүүлэгч	-	1ш	-	-	-	-	-	1ш	4ш
53	Лак арилгагч	-	30	-	-	-	-	-	30	120
54	Ариун цэврийн цаас	2ш	2ш	-	-	-	-	-	1ш	7ш
55	Салфетка	1уут	1уут	-	-	-	-	-	1уут	5уут
56	Баглаа, боодол, уут (полимер)	50г/10	50г/10ш	-	-	75г/15	-	-	50г/10ш	325г/65ш
57	Хуванцар сав	1ш	1ш	-	-	1ш	-	-	1ш	5ш
58	Даавуу	1м	1м	-	-	-	-	-	1м	4м
59	Хүүхдийн тоглоом	1ш	1ш	-	-	1ш	-	1ш	1ш	7ш
60	Ариун цэврийн хэрэглэл	1уут	1уут	-	-	-	-	-	1уут	4уут
61	Живх	10ш	10ш	-	-	-	-	-	10ш	40ш
62	Ахуйн хэрэглээний цэвэрлэгээний бодис /хивс, мебель шалд шаварлэгч г.м/	200	250	-	-	-	-	500	200	1350
63	Хуучин хувцас	-	2000	2000	-	-	-	-	-	6000
64	Хуучин гутал	-	1хос	1хос	-	-	-	-	-	3 хос
65	Химийн бодис /хуурай/	-	100	-	-	-	-	-	100	300
66	Ариутгал, халдваргүйтгэлийн	150	150	-	200	-	-	500	200	1400

Тайлбар:

1. Микробиологийн шинжилгээнд тухайн дээжийн хэмжээнээс үл хамааран сав баглаа боодол, хаяг шошго нь бүрэн бүтэн дээжийг тусад нь авна.
2. Гомдол, хордлого, хордлогот халдвар зэрэг онцгой тохиолдолд эрүүл ахуй халдвар судлалын шаардлагаар авсан сонгомол дээжийн хэмжээг тухайн нөхцөл байдлаас хамаарч улсын /ахлах/ байцаагч, тохирлын үнэлгээний мэргэжилтэн лабораторийн холбогдох мэргэжилтэнтэй зөвшилцсөний дагуу тогтооно.
3. Бүх төрлийн бүтээгдэхүүний дээжийн тоо хэмжээ нь дээж авсан болон өгсөн тухай тэмдэглэлд бүрэн бичигдсэн байна.

----- х X х -----



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох аргачлалыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стандарт, хэмжил зүйн салбарын ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох аргачлалыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Батлагдсан ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн, холбогдох бусад арга хэмжээ авч ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газар (Б.Ууганбаяр)-т даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Мөнх-Оргилд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД



С.АМАРСАЙХАН

0023100340

Ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох аргачлал

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэгт заасны дагуу Стандарт, хэмжил зүйн салбарын ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтооход энэхүү аргачлалыг мөрдөнө.

1.2. Энэхүү аргачлалын зорилго нь Стандарт, хэмжил зүйн газар болон тус газрын дэргэдэх Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ажил үйлчилгээг үзүүлэхэд холбогдон гарах бодит зардлын хэмжээг эдийн засгийн үндэслэлтэйгээр зөв тусгахад оршино.

1.3. Хэмжил зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 10 дугаар зүйлийн 10.3, 14 дүгээр зүйлийн 14.3, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 22 дугаар зүйлийн 22.1, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан аж ахуйн нэгж, байгууллагууд төлбөрийн хэмжээг тогтооходоо энэхүү аргачлалыг хэрэглэж болно.

Хоёр. Ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тооцох

2.1. Ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг байгууллагын зардлын гүйцэтгэл, тухайн ажлыг хийж гүйцэтгэх хөдөлмөр зарцуулалт, үйл ажиллагааны төрлүүдээр хуваарилагдах шууд болон шууд бус зардлуудын тооцоо, ажлын ачаалал, үр ашгийн түвшин нийт зардалд үндсэн цалингийн эзлэх хувь, нэгж хугацааны норм зэргийг тооцож тогтооно.

2.2. Ажил, үйлчилгээний төлбөр (Т)-ийн хэмжээг дараах томъёогоор тодорхойлно.

$$T = \frac{H_{ц} \times C}{K_{ц}} \times K_{м} \times (1 + Ш_{Б}) \times (1 + A) \times K_{\theta} \times K_{\varepsilon}$$

Үүнд:

$H_{ц}$ - ажлын хөдөлмөр зарцуулалт бөгөөд үүнийг дараах томъёогоор тодорхойлно.

$$H_{ц} = X_{ц} \times n \times K$$

$X_{ц}$ - нэгж хугацааны норм, цаг;

n - тухайн ажлыг хийж гүйцэтгэх ажилтны тоо, хүн;

K - ажил үйлчилгээний зохион байгуулалт, техникийн арга хэмжээ (ажлын байрыг шинэчлэн тоноглох, лабораторийн орчны нөхцөлийг бүрдүүлэх, ашиглалтын болон норматив техникийн баримт бичгийг судлах, тээвэрлэлтийн зардал, эталон хэмжих хэрэгслийн техник үйлчилгээ)-нд зарцуулах нэмэлт зардлыг тооцсон коэффициент бөгөөд тоон утга нь 1.1-1.3 хязгаарт байна.

C - ажилтны нэг цагийн хөдөлмөрийн хөлсний суурь үнэлгээ, цаг, төгрөг;

K_M - ажилтны мэргэжлийн ур чадвар, ажлын түвэгшлийн зэрэглэлийг илэрхийлсэн коэффициент бөгөөд тоон утга нь 1.0-1.5 хязгаарт байна.

$K_{ц}$ - нийт зардалд эзлэх цалингийн хувийн жинг илэрхийлсэн коэффициент;

$Ш_B$ -нийт зардалд эзлэх шууд бус зардлын хувийн жинг илэрхийлсэн коэффициент;

K_{θ} - тухайн оны зардлыг суурь оны зардалтай харьцуулсан өсөлтийн индексийн коэффициент;

A - Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн хувь хэмжээг илэрхийлсэн коэффициент;

$K_{э}$ - эталон ашиглалтын коэффициент; (Эталон хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг 10 жил ашиглахад өөрийн өртгийг үйл ажиллагааны орлогоос бүрэн нөхөх зарчмыг баримтлан тогтоосон бөгөөд тоон утга нь 1.0-1.5 хязгаарт байна.)

Гурав. Ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг инфляцтай уялдуулан тооцох

3.1.Инфляцын жилийн түвшин ($K_{и}$) 5%-аас дээш буюу доош өөрчлөлт орсон тохиолдолд төлбөрийг шинэчлэн тооцох үндэслэл болно.

Үүнийг тооцохдоо:

$$T_{и} = T \times K_{и}$$

$$K_{и} = \frac{100\% - K(\text{тухайн он})}{100\% - K(\text{тухайн он} - 1)}$$

$T_{и}$ - ажил үйлчилгээний төлбөрийг шинэчлэх хэмжээ;

$K_{и}$ - инфляцын жилийн түвшний өөрчлөлтийн коэффициент.

Төлбөрийн хэмжээг тогтоох аргачлалын коэффициент

Д/д	Ажил үйлчилгээ	Төрөл	Кц	Шб	Кө	Кэ
1.	Баталгаажуулалт	Бүтээгдэхүүн	0,61	0,16	1,12	-
		Менежментийн тогтолцоо	0,61	0,16	1,12	-
2.	Хэмжил зүйн салбар	Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт	0,44	0,15	1,04	1,0-1,5
		Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга	0,45	0,14	1,10	
		Хэмжих хэрэгслийн загварын туршилт хийж гүйцэтгэх	0,45	0,14	1,10	-
		Хэмжил зүй ажил үйлчилгээний чадавхыг үнэлэх	0,44	0,15	1,04	
3.	Үнэт металлын сорьц тогтоох	Хайлж гулдмайлах	0,4	0,12	1,39	1,0-1,5
		Химийн шинжилгээ	0,4	0,12	1,39	
		Сорьц дарах	0,4	0,12	1,39	
		Эрдэнийн чулуу гэрчилгээ олгох	0,4	0,12	1,39	
4.	Лабораторийн шинжилгээ	Шинжилгээний үнэ	0,49	0,13	0,89	1,0-1,5
		Хэмжилт шинжилгээний үнэ	0,49	0,13	0,89	
		Ур чадварын сорилтын үнэ	0,49	0,13	0,89	

___ х X х ___